



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/659

Булган сум

Г Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах  
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV дүгээр хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2023 оны XIV/01 дүгээр тогтоолоор батлагдсан Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 54 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дашинчилэн сумын ерөнхий боловсролын сургуулийн өмчлөлийн 380 кват-ын өндөр хүчдэлийн трансформаторыг шинэчлэх ажлыг зохион байгуулан, 15,000,000 (арван таван сая) төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг Дашинчилэн сумын Засаг дарга (Д.Луттөмөр)-д, Рашаант сумын хүн амын ус дамжуулах төвийн шугамын дамжуулах хоолой, худгийн насосыг солих ажлыг зохион байгуулан, 20,000,000 (хорин сая) төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг Рашаант сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Дашинчилэн сумын Засаг дарга (Д.Луттөмөр), Рашаант сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Дээрх ажлуудын санхүүжилтийг хууль, журам, гэрээний дагуу байгаль хамгаалах сангийн байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

